

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА САЛБАР, НЭГЖИЙН
АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ (2019-2021 ОН)**

2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар

№	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжилт
Зорилт 1. Ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг авах		
1.	1.1. Улс орны эдийн засгийн байдал, үнийн өсөлт, мөнгөний ханшийн бууралтын түвшнээс хамааруулж цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх	Ажилтнуудын цалин хөлсийг амьжиргааны өртгийн өөрчлөлт, үнийн өсөлт, мөнгөний ханшийн бууралтын түвшинтэй уялдуулж үе шаттайгаар нэмэгдүүлсэн. Тухайлбал: Ажилтнуудын үндсэн цалинг 2015 онд 10-26 хувиар, 2017 онд 10 хүртэл хувиар, 2018 онд 10-44 хувиар, 2019 онд 15 хувиар, 2020 онд 10 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Хоолны мөнгөний хөнгөлөлтийг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн бөгөөд 2010 онд өдрийн 3500 төгрөг, 2013 онд 4500 төгрөг, 2017 онд 10000, 2020 онд 15000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсөвт цалин хөлсийг нэмэгдүүлэх зардал тусгагдаагүй.
	1.2. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан цалин хөлс, шагнал урамшуулал олгох	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол, ЗГХЭГ-ын 2020 оны 100 дугаар тушаалд нийцүүлэн “ИНЕГ-ын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийг үнэлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, ИНЕГ-ын даргын 2021.03.30-ны өдрийн А/43 дугаар тушаалаар батлуулсан. Энэхүү журамд жил бүрийн 12 дугаар сард байгууллагын даргын тушаалаар үнэлгээний баг томилохоор тусгагдсан ба үнэлгээний баг нь нэгжийн даргын үнэлгээг хянаж, ажилтнуудыг шагналд тодорхойлох, шагнах урамшуулах санал гаргахаар тусгагдсан болно.
	1.3. Ажлын байрны чиг үүргийг оновчтой тодорхойлох, ачааллыг жигдрүүлэх арга хэмжээ авах	ИНЕГ-ын /агентлаг/ ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2019.04.22-ны өдрийн А/323 дугаар тушаалаар байгуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу 91 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ИНЕГ-ын даргын 2019 оны А/689 дүгээр тушаалаар баталгаажуулан мөрдөн ажиллаж байна. Мөн ЗТХС-ын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тушаалаар ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан агентлагийн 31 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. ИНҮТ-ийн даргын 2020 оны А/04 дүгээр тушаалаар ИНҮТ-ийн ажилтнуудын 60 албан тушаалын тодорхойлолт, 2020 оны А/121 дүгээр тушаалаар харьяа салбар нэгжүүдийн 328 албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан. ЗТХС-ын 2020 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн “Тушаал хүчингүй болгож, бүтцэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Б/171 дүгээр тушаалаар ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан ИНЕГ-ын даргын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн “Бүтэц шинэчлэн батлах тухай” А/391 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан бөгөөд ИНҮТ-ийн даргын А/163 дугаар тушаалаар 14 удирдлагын албан тушаалын тодорхойлолт, 2020 оны А/179 дүгээр тушаалаар ИНҮТ-ийн ажилтнуудын 65 албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан. Зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтөөр шинээр байгуулагдсан Спорт сургалтын төв, Нүүлгэн шилжүүлэлтийн ажлын хэсгийн орон тоо, албан тушаалын дагуу ажил үүргийг оновчтой тодорхойлж, ачааллыг жигд хуваарилах ажлын хүрээнд Нисэх буудлуудын үйлчилгээний газар, Худалдан авах ажиллагааны тасгийн нийт 49 албан тушаалын тодорхойлолтыг Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны А/42 дугаар тушаалаар баталсан.

		<p>ИНД140-ийн 140.51(2)-д заасан дүрмийн шаардлагын дагуу Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага, дотоод хяналтын албаны дарга нарын ажлын байрны тодорхойлолтод Иргэний нисэхийн багц дүрмийн шаардлагыг хангах талаар нэмэлт заалт оруулан батлуулсан.</p> <p>ДАА, ЗУГ хамтран НААХЗА-ны хүний нөөцийн үйл ажиллагаанд 2021.04.12-30-ны өдрүүдэд нийцлийн аудит шалгалт хийсэн. Шалгалтын дүгнэлтийг удирдлагуудад танилцуулж, НААХЗА-ны ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод холбогдох өөрчлөлтийг оруулахаар ажиллаж байна.</p>
	<p>1.4. Нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, хөнгөлөлт, тэтгэмж, тусламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох</p>	<ul style="list-style-type: none"> • Ажилтнуудын салбарт ажилласан жилийн судалгааг гаргаж, 2019 онд 128 ажилтанд, 2020 онд 605 ажилтанд, 2021 онд 272 ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгох хуваарийг батлуулж, хуваарийн дагуу удаан жил ажилласны нэмэгдлийг олгож байна. • ИНЕГ-ын даргын 2012.11.13-ны А/385, 2013.07.14-ны А/397 дугаар тушаалаар мэргэшсэн байх шаардлагатай албан тушаалын жагсаалтыг баталсан. Мөн ИНЕГ-ын даргын 2018.08.15-ны А/518 дугаар тушаалаар мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан, мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тухай бүр тушаалаар олгохоор заасан байдаг бөгөөд тушаалыг мөрдөн ажиллаж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 146 ажилтан мэргэшлийн зэргийн нэмэгдэл авч байна. • ИНЕГ болон харьяа салбар, нэгжийн ажилтнуудад шууд харьяалах нэгжийн дарга нь тодорхойлж, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүр ажлын үр дүнгийн 40 хүртэлх хувийн нэмэгдлийг олгож байна. • Хавсран ажилласан, орлон гүйцэтгэсэн ажилтанд нэмэгдлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгож байна. • ИНЕГ-ын даргын 2015 оны А/476, 2016 оны А/510 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад хэвийн бус нөхцлийн нэмэгдлийг олгож байна. • 2021 оны байдлаар хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдлийг 724 ажилтанд олгож байна. Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсээс дээрх судалгааг нягталж, 3 дугаар улиралд багтаан шинэчлэн батлуулахаар ажиллаж байна. • 2019 онд Төрийн одон медалиар 23 ажилтан, Засгийн газрын болон ЗТХЯ-ны шагналаар 85 ажилтан, ИНЕГ-ын шагналаар 118 ажилтан шагнагдсан. 2020 онд шинэ төрлийн коронавирусийн тархалтын улмаас Монгол Улсын хэмжээнд олон нийтийг хамарсан урлаг, спорт, баяр ёслолын арга хэмжээг хойшлуулсан. Олон улсын нислэгийн удирдагчдын өдөр, Хүний нөөцийн ажилтны өдөр, Шинэ жилийн баярыг тохиолдуулан ИНЕГ-ын Жуух бичиг, Баярын бичгээр 158 ажилтныг шагнаж урамшуулсан. Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 96 жилийн ойг тохиолдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021.05.24-ний өдрийн А/77 дугаар тушаалаар 69 ажилтан, ИНЕГ-ын даргын 2021.05.24-ний өдрийн Б/48 дугаар тушаалаар 240 ажилтныг шагнаж урамшуулсан.
Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах		
<p>2.</p>	<p>2.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийн шаардлагыг байгууллагын үйл ажиллагаанд хэвшүүлж, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 253 дугаар тушаалаар өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ЗТХС-ын 2020 оны “Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай” А/01 дүгээр тушаал, Зам, тээврийн салбарт 2020 онд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж улирал бүр ЗТХЯ-нд хүргүүлж ажилласан.</p> <p>ИНЕГ-ын даргын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/52 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэсгийг 3 орон тоотойгоор байгуулсан ба ИНҮТ-ийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан ИНЕГ-ын даргын А/391 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийг 4 орон тоотойгоор шинэчлэн байгуулсан. ИНЕГ-ын даргын 2020 оны А/225 дугаар тушаалаар ХНАА-нд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан хэсгийг 3 орон тоотойгоор байгуулсан.</p>

		<p>ИНЕГ-ын 2020 оны А/150 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. ИНЕГ-ын даргын 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн А/83 дугаар тушаалаар “ИНЕГ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр, ИНҮТ-ийн даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар “ИНҮТ-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус шинэчлэн байгуулсан.</p> <p>ИНЕГ-ын даргын 2019 оны А/688 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-д заасны дагуу ИНЕГ-ын ХАБЭА-н орон тооны бус зөвлөл нь 2020.03.27-2021.04.10, 2020.10.26-2020.12.04-ний өдрүүдэд 2 удаа ИНҮТ-ийн харьяа 10 салбар нэгж, орон нутгийн 15 нисэх буудлыг шалгаж, нийт 73 дутагдлыг илрүүлж, 17 дутагдлыг газар дээр арилгуулсан. Мөн 56 дутагдлыг арилгуулах талаар дэд зөвлөлүүдэд хугацаат үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>2020 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн “Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар нэгжийн галын аюулгүй байдлын үзлэг шалгалт хийх удирдамж”-ийг батлуулан 2020.06.18-2021.07.07-ны өдрүүдэд ХНАА, “Буянт Ухаа” ОУНБ, ГТҮШХА, СЗА-д галын аюулгүй байдлын үзлэг шалгалт хийж, үзлэгээр 55 дутагдлыг илрүүлэн, 15 дутагдлыг газар дээр нь арилгуулан, зөвлөгөө зөвлөмж өгч зөрчил, дутагдлыг арилгуулах талаар хугацаат үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан.</p> <p>ИНЕГ-ын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Навигацийн үзлэг зохион байгуулах тухай” А/418 дугаар тушаалын дагуу “Буянт-Ухаа” ОУНБ, НХҮА, ХНАА, ГТҮШХА, НУТА, НМҮА, НЖБА-ны ХАБЭА-н үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.</p> <p>ИНҮТ-ийн даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “ИНҮТ, түүний харьяа салбар нэгжийн галын аюулгүйн байдалд үзлэг хийх удирдамж”-ийн дагуу 2021.02.10-2021.02.14-ний өдрүүдэд Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Холбоо, навигаци ажиглалтын алба, Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд үзлэг шалгалтыг хийж гарсан 14 зөрчил дутагдлыг газар дээр арилгуулсан.</p>
2.2. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийг нийт ажилтнуудад сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах		<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж, стандартуудыг Нисэхийн сургалтын төвийн цахим хуудсанд байршуулж нийт ажилтнуудад сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Нисэхийн сургалтын төвийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан. ХАБЭА-н сургалтад 2020 онд 864 ажилтныг, 2021 онд 335 ажилтныг хамруулсан.</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ийг ИНЕГ-ын даргын 2018 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн А/139 дүгээр тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.</p> <p>ИНҮТ-ийн даргын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/76 дугаар тушаалаар “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ыг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.</p> <p>2019 онд 6, 2020 онд 10, 2021 онд 1 үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдол бүртгэгдсэн.</p> <p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд: ИНЕГ, ИНҮТ-д нийлүүлэгдэж байгаа цэвэр усны хангалтын эх үүсвэрт хяналт тавих зорилгоор Мэргэжлийн хяналтын лабораторийн шинжилгээний бичгийг улирал бүр нийлүүлэгч компаниас авч ажиллаж байна.</p> <p>Орон нутгийн нисэх буудлуудаас өдөр тутмын ХАБЭА-н мэдээг тогтмол цахимаар авч хяналт тавьж ажиллаж байна.</p>

<p>2.3. Дүрэмт хувцас болон хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах албан тушаалтнуудын жагсаалт, эдэлгээний норм, нормативыг тогтоож, тушаалаар баталгаажуулж, мөрдүүлэх</p>	<p>Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин, Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх анхааруулга, санамж зөвлөмжийг ХАБЭА хариуцсан ажилтнууд вайбер группээр тогтмол өгч байна.</p> <p>ИНЕГ-ын даргын 2015 оны “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, сүү, цэвэрлэгээ, үйлчилгээний материалын жагсаалт, эдэлгээний нормыг шинэчлэн батлах тухай” А/625 дугаар тушаалын дагуу ажилтны ажлын байрны нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр болон хор саармагжуулах бодисоор хангаж байна.</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны дүрэмт хувцас болон хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлд 2020 онд 1,152,277.8 мянган төгрөг, ИНУТ-ийн харьяа алба, нэгжийн ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэлд 567,302,800 төгрөг зарцуулагдсан байна.</p> <p>2020 онд ажлын нөхцөл, онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд 572,219,400 төгрөгийг зарцуулж, 1101 ажилтныг хамгаалах хэрэгслээр хангасан.</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Иргэний нисэхийн үндэсний төв нь 2021 онд хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлд 712,8 сая төгрөг төсөвлөж баталсан.</p> <ul style="list-style-type: none"> • <u>“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал:</u> Хөдөлмөр хамгааллын /өвлийн ажлын хувцас, өвлийн гутал, цацруулагчтай хантааз, гагнуурын бээлий, хөвөнтэй бээлий, ажлын бээлий, нүдний дусаалга, нүдний шил/ хувцсаар давхардсан тоогоор 148 ажилтанд олгосон. Хөдөлмөр хамгааллын хувцсыг нисэх буудлын хэмжээнд нийт 3 угаалгын машинаар цэвэрлэгээ хийж байна. Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нисэх буудлын 17 нэгжийн ажилтнуудад нэг удаагийн амны хаалт нийт 39273, N95 амны хаалт 739, хатаасан аарц 710 ширхгийг тус тус олгосон. Мөн Үйлдвэрлэлийн нэгжийн ээлжийн ажилтнуудад хамгаалалтын комбинзон-768, комбинзоны улавч 707, нүүрний хаалт 878, нэг удаагийн малгай 4491, халаад 32, нэг удаагийн бээлий 6611, зайнаас халуун хэмжигч 3 ширхэг, гар ариутгагч /санитол/ 554 литр тус тус хангасан. • <u>Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба:</u> Хөдөлмөр хамгааллын зуны ажлын хувцас, хантаазаар 16 ажилтанг хангасан. 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийн 2021 оны тендер зарлагдаад явж байна. “Болор сервис” ХХК-ийн хими цэвэрлэгээнд ажлын хувцсыг 17, “UB express” ХХК-ийн хими цэвэрлэгээнд нийт 8 удаа /14 хоногт нэг удаа/ өгч цэвэрлүүлсэн. Хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад ажилд гарсан цагийг үндэслэн “Сүү” ХХК-тай гэрээ байгуулж 223 литр ариутгасан сүүг 21 инженер, техникийн ажилтанд, хэвийн бус нөхцөлийн 10 хувийн нэмэгдлийг 23 ажилтанд сар бүр тогтмол олгож байна. • <u>Холбоо, навигаци, ажиглалтын алба:</u> Тус албаны Инженер техникийн ажилтнуудад 2020 онд олгогдох байсан хөдөлмөр хамгааллын хувцсыг 2021 оны 7 сард комисс хүлээн авч “Як трейд” ХХК-аас Зуны хувцас: 87ш /хос/, Өвлийн хувцас: 123ш /хос/, Өвлийн гутал: 114ш, Мөн Их алдар ХХК-с Зуны гутал: 66ш 2021.08 сард комисс ажиллаж хүлээн авсан. Хувцас тараалт 50% явагдаж байна. Өндөр хүчдэлд хэрэглэгддэг 11 хамгаалах хэрэгслийг УБЦТС-р, нийт 23 багажийг Стандарт хэмжил зүй газар баталгаажуулсан. • <u>Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба:</u> Ажлын дүрэмт хувцас 82, эмчийн халаад 3 ажилтанд олгосон. Хэвийн бус нөхцөлийн 10 хувийн нэмэгдлийг 124 ажилтанд сар бүр тогтмол олгож байна. • <u>Оношилгоо, хэмжил зүйн лаборатори:</u> Хэмжилт, шалгалт тохируулга, сорилт шинжилгээ гүйцэтгэдэг 12 ажилтанг ажлын нөхцөл, онцлогт тохирсон дараах тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан. Үүнд: ажилтнуудад халаад, ажлын бээлий, химич инженерүүдэд хошуувч, нэг удаагийн резинэн бээлий, хүчил, шүлтэд тэсвэртэй резинэн бээлий тус тус олгож, бүртгэл хөтөлсөн. Химич инженерүүдийн 12ш халаадыг “Нарта” хими цэвэрлэгээнд угааж, цэвэрлүүлж байна. Иргэний нисэхийн
---	--

		ерөнхий газрын даргын 2017 оны А/534 дүгээр тушаалд заасан нормын дагуу ажилтнуудыг өдөрт 0,5 литр хор саармагжуулах бүтээгдэхүүнээр тогтмол хангасан.
Зорилт 3. Ажилтнуудын амьдрах орчин нөхцлийг сайжруулах		
3.	3.1. Ажилтнуудын орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, дүн шинжилгээ хийх	2021 оны 11 дүгээр сарын сарын байдлаар орон сууцны хөнгөлөлт хүсч өргөдөл гаргасан ажилтнуудын судалгааг шинэчлэн гаргасан. ИНЕГ-ын хэмжээнд орон сууцны үнийн хөнгөлөлт хүсч өргөдөл гаргасан 10, ИНҮТ, түүний харьяа салбар нэгжийн хэмжээнд 733 ажилтан байна.
	3.2. Ажилтнуудыг амьдрах орчин нөхцлөө сайжруулах, орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлэх	2019 онд батлагдсан төсвийн хүрээнд нийт 70 ажилтанд орон сууцны дэмжлэг олгосон. МУЗГ-ын 2020.02.28-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 78 дугаар тогтоол, 2021.02.17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллаж байгаатай холбогдуулан 2020, 2021 оны төсөвт орон сууцны дэмжлэгийн зардал батлагдаагүй тул дэмжлэг олгоогүй.
Зорилт 4. Ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах		
4.	4.1. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан тухайн албан тушаалд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслээр хангах	2019 онд 27,067,900 төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 7,490,000 төгрөгийн тавилга худалдан авсан. 2020 онд 96,253,518.71 төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 41,771,501.97 төгрөгийн тавилга худалдан авсан. 2021 онд 68,972,284.85 төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 80,702,744.68 төгрөгийн тавилга худалдан авсан.
	4.2. Дэвшилтэт шинэ тоног төхөөрөмж, технологийг ажил албандаа нэвтрүүлэх, цаасгүй технологи бий болгох, шинэ арга барилыг байнга эрэлхийлж хэрэгжүүлэх	ИНЕГ-ын хуримтлагдсан ашгаас санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ИНЕГ-ын шинэ оффис, бүсийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн “Принт менежмент” системийг нэвтрүүлэх ажил тусгагдан, 2019 онд тендер шалгаруулалтыг зохион байгуулж Таванбогд Солюшнс ХХК шалгарч 123.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Бүсийн хөдөлгөөний удирдлагын шинэ төв ашиглалтад ороход суурилуулалтыг хийхээр төлөвлөсөн. “Принт менежмент” систем нь хэвлэгч, хувилагч тоног төхөөрөмжүүдийг нэгдсэн удирдлагатай болгох систем бөгөөд нэгдсэн удирдлагатай болсноороо хэвлэх хувилах ажлын зардлыг хэмнэх, илүү үр ашигтай, цаг хэмнэсэн ажлын урсгалыг бий болгох мөн бичиг баримтын нууцлал, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах юм. 2021 онд “Принт менежмент” системийг нэвтрүүлж, нэгдсэн удирдлагатай хэвлэгчийг ИНЕГ, ИНҮТ-д суурилуулсан. Үүнд: ИНЕГ-ын хэмжээнд 2 хар, 1 өнгөт принтер, ИНҮТ-ийн хэмжээнд 3 хар, 1 өнгөт принтерийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Иргэний нисэхийн салбарт дэвшилтэт шинэ тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх чиглэлээр дижитал шилжилтийг хэрэгжүүлэх, их өгөгдөл (Big Data)-ийн судалгаа болон Дата төвийн 3 судалгааг тус тус хийсэн.
	4.3. Ажилтнуудын үдийн амралтын үеэр богино хугацаанд алжаал тайлах /цай, кофе уух, сонин сэтгүүл унших гэх мэт/ амрах өрөө тасалгаа болон шаардлага хангасан цайны газартай болгох	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албан дээр Шинээр баригдаж буй бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн оффисын барилгад ажилтнуудад зориулсан цайны газар байгуулах, кофе шоп ажиллуулахад зориулж өөрийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 167.7 сая төгрөгөөр тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдсэн. 2017 онд ИНЕГ-ын хурлын танхимын нэг буланг тохижуулж, ажилтнуудыг үдийн цайгаа тав тухтай уух боломж нөхцөлөөр бүрдүүлсэн. Хөргөгч, печь, ус буцалгагч гэх мэт эд хогшлоор хангасан.

		<p>Эрүүл мэнд, спортын цогцолбороор үйлчлүүлэгдэд зориулсан цайны газар, кофе шоп ажиллуулах 46.98 мк.в өрөө тасалгааг тохижуулахаар ажиллаж байна.</p> <p>Мөн Холбоо, навигаци, ажиглалтын албаны амралтын өрөөнд 4 хос ор авч, байрлуулсан. Баянхонгор аймгийн нисэх буудалд кофе шоп ашиглалтад оруулсан. “Баруун-Урт” нисэх буудалд ажилчдын богино хугацаанд алжаал тайлах амрах өрөөг тохижуулсан. “Гурвансайхан” нисэх буудал цайны өрөө бий болгон тохижуулсан. “Алтай” нисэх буудалд цай, кофегоор үйлчлэх бүфет, амрах өрөөг тохижуулсан.</p>
4.4. Ажлын байрны тохижилт, шинэчлэлтийг орчин үеийн стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх	<p>ИНҮТ-ийн дэд даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-нд баталсан удирдамжийн дагуу ЧХОУНБ, ГТҮШХА, НХҮА, НМҮА, НЖБА, ХНАА-нд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үзлэг шалгалт хийж, ЧХОУНБ-д 8, ГТҮШХА-нд 2, НХҮА-нд 1 ажлын байрны нөхцөлийг тус тус сайжруулах зөвлөмжийг хүргүүлсэн</p> <p>Ажлын байр болон Спорт сургалтын төвд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн судалгааг гаргасан.</p> <p>Ажилтнуудын ажлын байрны нөхцлийг сайжруулахад шаардлагатай 357.5 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авч хуваарийн дагуу эзэмшүүлсэн.</p> <p>ИНҮТ-ийн өөрийн орлогоос санхүүжих 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ажилтнуудын албан хэрэгцээнд шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийг 490.0 сая төгрөгөөр худалдан авахаар төсөвт суулгаж, батлуулсан. Худалдан авалтыг зохион байгуулах ажлыг ХААТ хариуцан ажиллаж байна.</p> <p>2021 оны 4 дүгээр сард НААХЗА-ны ажилтнуудын ажлын байрыг ИНЕГ-ын байранд шилжүүлж, НААХЗА-ны хуучин байранд ИНҮТ-ийн ажилтнуудыг шилжүүлэн байрлуулж үйл ажиллагааны чиглэлээр нь нэгтгэн байршуулсан. Үүнтэй холбогдуулан НААХЗА-ны ажилтнуудын тавилга, эд хогшлыг шинэчилсэн.</p> <p>Мөн Монголиан Эйрвэйз карго ХХК-ийн түрээсийн байранд байрлаж байсан нэгжүүдийг Буянт-Ухаа нисэх буудлын өрөөнүүдэд тараан байрлуулж тохинуулсан.</p>	
Зорилт 5. Ажилтнуудын эрүүл мэндийг сахин хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сайжруулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх		
5.	5.1. Эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах	<p>Гранд мед эмнэлэгтэй гэрээ байгуулж, 2019 онд 1717 ажилтныг, 2020 онд 713 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хуваарийн дагуу хамруулсан.</p> <p>2021 оны төсөвт ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар 125.2 сая төгрөг тусгагдсан. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендет “Асралт мед” ХХК сонгон шалгарч, 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр хамтын ажиллагааны гэрээ байгуулж, 900 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар болсон. Урьдчилан сэргийлэх үзлэг 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн зохион байгуулагдаж байна.</p> <p>“Гурван сайхан” нисэх буудал нь 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр аймгийн “Шим билэг” өрхийн эмнэлэгийн эмч нар тус нисэх буудлын 34 ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.</p>
	5.2. Нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрт нь эмчилгээ, сувилгаа болон витаминжуулалтад хамруулах зэргээр эрүүл мэндээ хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх	<p>Эрүүл мэндийн даатгалд 2019 онд 345 ажилтныг Тэнгэр даатгал ХХК-тай, 2020 онд 667 ажилтныг Бодь даатгал ХХК-тай гэрээ байгуулж даатгуулсан.</p> <p>Ажлын хариуцлага, амь нас, гэнэтийн ослын даатгалд 2020 онд 200 ажилтныг, 2021 онд 200 ажилтныг Практикал даатгалд тус тус даатгуулсан.</p> <p>Иргэний нисэхийн салбарын мэргэжлийн эмч нар ажилтнуудын 2019 оны эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлттэй танилцан, 2020 онд нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх шаардлагатай 64 ажилтныг “Баатарван” амралт, сувиллын газарт нөхөн сэргээх эмчилгээнд хамруулсан. “Баатарван” амралт, сувиллын газарт 2021.06.06-ны өдрөөс эхлэн 280 ажилтныг нөхөн сэргээх, эмчилгээ сувилгаанд хамруулахаар хуваарийн дагуу хамруулж байна.</p> <p>Иргэний нисэхийн үндэсний төвийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран 2020 оны 3 дугаар сард витаминжуулалтын аян зохион байгуулж чацаргана, халуун аарцаар ажилтнуудыг хангасан.</p>

	<p>Сэргээн засах амралтаас Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дараах дархлааг дэмжих, нөхөн сэргээх үйлчилгээний хөнгөлөлттэй үнэ бүхий CARE хөтөлбөрийг ажилтнууддаа зориулан 2021 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн Эрүүл мэнд, спортын цогцолбороос INBOdy төхөөрөмж /хүний биеийн үзүүлэлтийг ерөнхий 5 төрөлөөр гаргах/-ийг ашиглан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнтэй уялдуулан спортын төрлөөр хичээллүүлэхээр төлөвлөж байна.</p>
5.3. Эмнэлгийн нэг өрөөг тохижуулж, албан хаагчдын хэвтэн эмчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх	<p>“Чингис хаан” ОУНБ-тай хамтарч 3 дугаар нэгдсэн эмнэлгийн Мэдрэл, мэс заслын тасгийн хоёр ортой нэг өрөөг тохижуулахаар судалгаа гаргасан. НХҮА-ны эмчийн гаргасан тоног төхөөрөмжийн судалгаанд үндэслэн ИНЕГ-ын хуримтлагдсан ашгаас санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх” 27.3 сая төгрөгийн ажлыг тусгасан.</p> <p>Улсын 1 дүгээр төв эмнэлгийн бөөрны тасгийн 1 өрөөнд 2 эмчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх хамтран ажиллах гэрээг 2021 онд НХҮА-наас шинэчлэн байгуулсан. Цаашид Клиникийн нэгдсэн 3 дугаар эмнэлэгтэй хамтран ажиллах нөхцөл боломжийг судалж байна.</p> <p>Эрүүл мэнд, спортын цогцолборын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, зөвлөгөө өгөх эмнэлгийн хэсэг байрлах 340см x 320см, 340см x 287см өрөөг тохижуулахаар бэлтгэсэн. Тус өрөөг тохижуулахад шаардагдах зардал, төсвийн тооцоог ИНҮТ-ийн Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн.</p>
5.4. Ажлын байран дээр ажилтнуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх эмчийг ажиллуулах	<p>2019-2020 онд “Буянт-Ухаа” нисэх буудал, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Сэргээн засах амралтад ажилтнуудад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх эмнэлгийн хэсэг, эмч ажиллаж байсан.</p> <p>Иргэнийн нисэхийн үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан ИНҮТ-ийн даргын 2021 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн Б/414 дугаар тушаалаар Спорт сургалтын төв нь Эрүүл мэнд, спортын цогцолбор болон өөрчлөгдсөн. Тус цогцолбор нь 5 их эмч, 2 сувилагчын бүрэлдэхүүнтэй ажилтнуудын эрүүл мэнд яаралтай анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмийн бус эмчилгээ болон бариа засал хийх, зөвлөгөө өгөх эмнэлгийн хэсгийг “Буянт-Ухаа” нисэх буудлын 1 дүгээр давхарт ажлын 8 цагаар ээлжлэн ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. 2021 оны 6 дугаар сарын 01-нээс 9 дүгээр сарын 9-ний өдрийн хооронд дараах үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ● Нийт яаралтай тусламжийн дуудлаганд анхан шатны яаралтай тусламж үзүүлж зөвлөгөө өгсөн хүний тоо – 4 ● Эмчийн үзлэг хийж, клиникийн урьдчилсан онош тавьж зөвлөгөө өгсөн хүний тоо - 249 ● Ковидийн тандалтын түргэвчилсэн шинжилгээ /шүлсээр/ авсан хүний тоо – 61 <p>Эмийн болон эмийн бус эмчилгээ үйлчилгээ үзүүлсэн 119 ажилтан байна. Үүнээс эмчилгээний төрөл авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ● Бариа засал 18 ● Бумба засал 12 ● Шарлага эмчилгээ 16 ● Эмийн эмчилгээ 72 ● Тариа эмчилгээ 80 ● Шарх цэгцлэлт боолт 10
5.5. Ажилтнуудыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, спортын уралдаан	<p>2019 онд Сэргээн засах амралтад “Хаврын баяр” нэгдсэн арга хэмжээг уулын алхалт, олс таталт, хөлбөмбөг, уулын оргил булаалдах зэрэг спортын хөтөлбөртэйгээр зохион байгуулсан. Мөн ИНЕГ-ын Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн дунд спортын 4 төрлийн тэмцээн, Зам, тээврийн салбарын спортын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээн, Иргэний агаарын тээвэрчдийн өдөрт зориулсан салбарын аварга шалгаруулах спортын 6 төрөлт тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Нийслэлийн засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафон-2019” олон улсын гүйлтийн уралдаанд байгууллагыг төлөөлж 8</p>

<p>тэмцээн зохион байгуулах, спорт зааланд тогтмол тоглуулах, аэробек, бүжгийн секц, иога, усан бассейнд явуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, байгууллагын спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулах</p>	<p>ажилтан оролцсон. ИНЕГ, түүний харьяа алба, салбарын албан хаагчдын дунд "Бие бялдрын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-ыг 2019 оны 04 дүгээр сард зохион байгуулан ажиллаж, орон нутаг, алба салбаруудын нийт 1000 гаруй ажилчид хамрагдав.</p> <p>2020 онд Нислэгийн удирдагчдын өдөрт зориулан сагсан бөмбөгийн тэмцээн, Үйлдвэрчний эвлэлийн холбооны нэрэмжит 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулсан. Иргэний агаарын тээвэрлэгчдийн өдрийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг салбарын аварга шалгаруулах спортын 6 төрөлт тэмцээнийг 2020 оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн байсан боловч цар тахлын улмаас хойшлогдсон.</p> <p>2021 оны 9 дүгээр сараас эхлэн Эрүүл мэнд, спортын цогцолборт иога, бүжгийн сургалт явагдаж, ажилтнууд идэвхитэй хамрагдаж байна. Усан бассейны үйл ажиллагаа 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс нээгдэж, бүртгэлээ авч эхэлсэн. Чийрэгжүүлэх танхимыг 10 дугаар сард шилжүүлэн тохижуулж, ширээний теннисний тоглолт эхлүүлэн, иогийн дасгалд хамрагдах ажилтнуудын бүртгэлийг эхлүүлээд байна. Мөн өдөр тутмын дасгал хөдөлгөөний зурагт хуудсыг ИНҮТ-ийн алба салбаруудад ажлын байранд, Эрүүл мэнд, спортын цогцолборын пэйж хуудсанд видео хичээлүүдийг байршуулсан.</p> <p>Tiger спорт заалтай 2020 оны 12 дугаар 23-ны өдрийг хүртэл, "Encanto" спорт заалтай 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл хамтран ажиллах гэрээг байгуулж ажилласан.</p> <p>"Алтан намар-2020" явган аяллыг Манзушир-Цэцээ гүн-Төр хурах чиглэлд 15 км-ийн маршрутаар 9 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж 55 ажилтан хамрагдсан.</p>
<p>5.6. "Эрүүл агаар - эм" сэдэвт идэвхитэй амралт, явган болон тойрон аяллыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах</p>	<p>2019 онд Сэргээн засах амралтад "Хаврын баяр" нэгдсэн арга хэмжээг уулын алхалт, олс таталт, хөлбөмбөг, уулын оргил булаалдах зэрэг спортын хөтөлбөртэйгээр зохион байгуулсан. 2020-2021 онд Ковид-19 цар тахлын улмаас олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулагдахгүй байгаа болно.</p>
<p>5.7. Ажилтнуудад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох сургалт зохион байгуулах, эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гарын авлага, ном товхимлоор ажиллагсдыг хангах, ухуулга сурталчилгааны хуудсыг мэдээллийн самбарт байрлуулж сурталчилж ажиллах</p>	<p>ИНЕГ-ын "Мэдээллийн цаг"-аар "Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв"-тэй хамтран "Дасгал хөдөлгөөн-Зохистой хооллолт" сэдэвт сургалтыг 2019 оны 06, 12 дугаар сард тус тус зохион байгуулсан.</p> <p>2020 онд "Дархлаажуулалт, витаминжуулалтын сарын аян"-ыг 5 дугаар сард зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд нийт 6 цуврал хичээлийг видео хэлбэрээр цахимаар зохион байгуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Зөв зохистой хооллолт ба эрүүл мэнд; ✓ Ажлын байран дахь дасгал хөдөлгөөн; ✓ Дасгал хөдөлгөөн ба эрүүл мэнд; ✓ Спортын дасгал хөдөлгөөн, бариа засал; ✓ Биеийн эмгэг засал; ✓ Бясалгал, иог төвлөрөл <p>Мөн "Зөв зохистой хооллох энгийн дүрмүүд", "Чандмань эрдэнэ болон усны мэдээлэл", "Ажлын байран дахь дасгал хөдөлгөөн" зэрэг зурагт хуудсыг ажлын байруудад байршуулж, сурталчлан таниулсан.</p> <p>2020 оны 1 дүгээр сард "Уламжлалд суурилсан ёс суртахуун" сэдвээр Амьдрах ухаан төвийн багш Н.Отгонбаяртай хамтран лекц сургалт зохион байгуулсан.</p> <p>2021 оны 4 дүгээр сард "Фитнес, Азобикийн үндэс, дасгал хөдөлгөөн" сэдэвт онлайн сургалт, 5, 6 дугаар сард "Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөн" цуврал видеог 2 удаа онлайнаар хүргэсэн.</p>
<p>Зорилт 6. Ажилтнуудын сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх</p>	

6.	<p>6.1. Ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, түүнд шаардагдах зардлыг байгууллагын жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх</p>	<p>2019 онд гадаад улсад зохион байгуулагдсан 96 сургалтад давхардсан тоогоор 728 ажилтан, НСТ-д зохион байгуулсан 53 сургалтад 1966 ажилтнууд, дотоодын сургалтын байгууллагад зохион байгуулагдсан 91 сургалтад 706 ажилтан хамрагдсан. 2019 оны 7 сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан батлуулсан бөгөөд нийт 176 хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.</p> <p>2020 онд нийт 12 сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулан сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд хяналтын шатанд нийт 12 хөтөлбөр боловсруулагдаж байна.</p> <p>Нисэхийн сургалтын төвд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан 53 сургалтаас 40 сургалтыг 156 ээлжээр зохион байгуулж, 2063 ажилтныг хамруулж, гэрчилгээжүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтэд мэргэшүүлэх, анхан, давтан чиглэлээр 31 төрлийн сургалт 95,2%-тай зохион байгуулагдсан. 2020 онд төлөвлөгөөт бус нийт 14 сургалт зохион байгуулагдсан. Үүнд шинэ төрлийн коронавирусын цар тахлын улмаас гэрээсээ ажиллаж буй ажилтнуудад зориулсан 1 зайн сургалтад 29 ажилтан, НХҮА-ны НУ, НМА-ны “Чингис хаан” ОУНБ-д шилжих 1 сургалтад 166, УБ хотын шинэ нисэх буудлын үйл ажиллагаа ашиглалтад орохтой холбоотойгоор ИНҮТ-ийн болон Нью Улаанбаатар Интернэшнл Эйрпорт ХХК-ийн хооронд байгуулсан 65/20 дугаар гэрээний дагуу 12 сургалтад 122 ажилтан хамрагдсан.</p> <p>Гадны сургалтын байгууллагуудад 2020 онд зохион байгуулагдах 92 сургалтаас 16 сургалт зохион байгуулагдаж, 69 мэргэжилтэн хамрагдаж, гэрчилгээжээд байна. ИНЕГ-ын даргын 2020 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжиж ажиллах тухай” А/205 дугаар тушаалын дагуу сургалтын үйл ажиллагааг зайлшгүй шаардлагатай, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй сургалтуудыг зохион байгуулсан.</p> <p>2021 оны сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах сургалтын 2 хөтөлбөрийг шинээр, 8 хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан. НСТ-д 2021 онд зохион байгуулагдах дотоод сургалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу ИНҮТ-ийн 11 салбар, нэгжийн 57 сургалтыг 130 ээлжээр 2759 ажилтан хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 2021 оны 3-р улирлын байдлаар 18 сургалтад нийт 1383 ажилтан хамрагдсан. Төлөвлөгөөт бус 13 сургалтад 477 ажилтан хамрагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 45%-тай байна.</p> <p>Гадны сургалтын байгууллагуудад 2021 онд зохион байгуулагдах дотоод сургалтын төлөвлөгөө”- ний дагуу 21 сургалтад нийт 133 ажилтан хамрагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 22,1%-тай байна.</p>
	<p>6.2. Ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн төсөл боловсруулах зэрэг чиглэлээр ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулах</p>	<p>2019 онд ИНЕГ болон түүний харьяа алба салбаруудад шинээр орсон ажилтан, албан хаагчдад ИНЕГ-т мөрдөгддөг хууль, дүрэм, журам, заавруудын талаар ИНЕГ-ын даргын А/913 дугаар тушаалын дагуу Нисэхийн сургалтын төвд 2 удаагийн сургалт зохион байгуулж, ИНЕГ-ын харьяа алба салбаруудын нийт 25 ажилтан хамрагдсан.</p> <p>2020 онд ИНЕГ-ын хөдөлмөрийн дотоод журам, иргэний нисэхийн багц дүрмүүд, бусад хууль, эрх зүйн мэдлэг олгох “Иргэний нисэхийн үйл ажиллагаатай танилцах 24 цагийн сургалт”-ыг зайн хэлбэрээр зохион байгуулан ажиллаж, сургалтад 4 ээлжээр төв болон орон нутгийн нисэх буудлын нийт 38 ажилтныг хамруулсан. Иргэний нисэхийн үндэсний төвийн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, тус төвд мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар 1 удаа сургалт хийж, 23 ажилтныг хамруулсан.</p> <p>- Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран 2020 оны 09 дүгээр сард “Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын талаарх сургалтыг зохион байгуулж 45 ажилтан хамрагдсан. ИНЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/416 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Иргэний нисэхийн үндэсний төвийн 49 ажилтанд танилцуулга-сургалт орж, давхардсан тоогоор 117 ажилтан хамрагдсан.</p> <p>Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн хүрээнд ажилтнуудын архив, албан хэрэг хөтлөлтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг</p>

	цахимаар 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад ИНЕГ, ИНҮТ-ийн 100 ажилтан хамрагдсан. Мөн МТИА-аас iMCAA системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан 2021 оны 2, 3 дугаар саруудад модулиудыг танилцуулах сургалтыг ИНЕГ, ИНҮТ, түүний салбар, нэгжийн удирдлага болон архив, албан хэрэг хөтлөлт, захиргааны ажилтнуудыг бүрэн хамруулаад байна. 2021 оны 3 дугаар сард “Төрийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх, данс, бүртгэл үйлдэх ажлын арга зүй сургалт”-д 1 ажилтан, 9 дүгээр сард “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт анхан шатны сургалтад 1 ажилтан хамрагдаж гэрчилгээжсэн.
6.3. Ажилтнуудад гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол олгоход анхаарч, байгууллагаас зохих дэмжлэг үзүүлэх	ИНЕГ-ын даргын 2019 оны А/198 тоот тушаалаар “Ерөнхий англи хэлний суурьтай анхан шатны 40 цагийн сургалт”-ыг 2019 оны 03 дугаар сарын 18-29-ний хооронд хоёр ээлжээр зохион байгуулан ажиллаж нийт 30 ажилтан хамрагдав. Мөн ИНЕГ-ын даргын 2019 оны А/310 тоот тушаалаар “Ерөнхий англи хэлний дундын доод түвшний 40 цагийн мэдлэг олгох сургалт”-ыг 2019 оны 04 дүгээр сарын 10-23-ны хооронд зохион байгуулан ажиллаж нийт 14 ажилтан хамрагдав. ИНЕГ-ын даргын 2019 оны А/638 дугаар тушаалаар “Англи хэлний дундын доод түвшний сургалт” зохион байгуулж, 10 ажилтан, ИНЕГ-ын даргын А/839 тушаалын дагуу “Ерөнхий англи хэлний яриа сонсголын ур чадвар дээшлүүлэх сургалт” зохион байгуулж, 9 ажилтан хамрагдав. 2020 онд Ерөнхий англи хэлний суурьтай анхан, дундын доод, дунд гэсэн 3 түвшний сургалтууд болон яриа сонсгол хөгжүүлэх сургалтуудыг 2 удаагийн давтамжтайгаар зохион байгуулахаар тусгасан боловч Шинэ төрлийн короновирус цар тахлын улмаас гэрээсээ ажиллаж буй ажилтнуудад зориулан дээрх сургалтуудыг зайн хэлбэрээр зохион байгуулсан. Англи хэлний суурьтай анхан, дундын доод, дунд түвшний зайн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулж, ИНҮТ-ийн даргын А/35 дугаар тушаалаар 2020 оны 4 дүгээр сарын 06-30-ны өдрүүдэд сургалтуудыг ZOOM програмаар зохион байгуулсан бөгөөд 41 ажилтан хамрагдав. Нисэх буудлын ажилтнуудын англи хэлний яриа сонсголын ур чадвар дээшлүүлэх зорилгоор “Зорчигч үйлчилгээний ажилтнуудад зориулсан ерөнхий англи хэлний яриа сонсголын ур чадвар дээшлүүлэх сургалт”-ын хөтөлбөрийг боловсруулан батлуулсан. ИНҮТ-ийн даргын А/105 дугаар тушаалаар 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 03-ны өдрүүдэд “Буянт Ухаа” Олон улсын нисэх буудалд 2 ээлжээр зохион байгуулж нийт 14 ажилтан хамрагдав. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан “Ерөнхий англи хэлний суурьтай анхан болон дунд түвшний сургалт”-уудыг ИНҮТ-ийн даргын Б/423 дугаар тушаалаар 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрүүдэд “Буянт Ухаа” Олон улсын нисэх буудалд тус тус зохион байгуулж нийт 43 ажилтан хамрагдав. “Зорчигч үйлчилгээний ажилтнуудад зориулсан ерөнхий англи хэлний яриа, сонсголын ур чадвар дээшлүүлэх сургалтад 2021 оны 3-р улирлын байдлаар ИНҮТ-ийн 154 ажилтан, Ерөнхий англи хэлний суурьтай анхан шатны 16 цагийн зайн сургалт”-д 18 ажилтан, нийт 172 ажилтан хамрагдсан. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанаас Олон улсын англи хэлний түвшин хадгалах, ахиулах сургалтад 9 нислэгийн хөдөлгөөний удирдагч хамрагдсан.
6.4. Байгууллагын захиалгаар 1-3 сарын хугацаагаар үндсэн ажлаасаа чөлөөлөгдөн гадаад оронд сургалтад хамрагдаж буй ажилтанд дэмжлэг үзүүлэх	2019-2021 онд байгууллагын захиалгаар 1-3 сарын хугацаагаар үндсэн ажлаасаа чөлөөлөгдөн гадаад оронд сургалтад хамрагдсан ажилтан байхгүй байна.
6.5. Бие даан болон хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах болон хэлний сургалтад хамрагдаж байгаа ажилтнуудыг дэмжиж, мэдлэг,	2019 онд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэхийн зэрэгцээ суралцаж буй 2 ажилтанд ажлын цагийн зохицуулалтыг хийж мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангасан. Мэдлэг, боловсролоо дээшлүүлэхээр үндсэн ажлаас чөлөөлөгдөлгүйгээр суралцаж буй 4 ажилтанд сургалтын төлбөрийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгосон. 2020 онд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтны хүсэлтийг харгалзан мэргэжил боловсролоо дээшлүүлж байгаа 12 ажилтныг суралцах нөхцөл боломжоор ханган ажлын зохицуулалт хийсэн. ИНЕГ, түүний харьяа салбарын 2

	<p>мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангах</p>	<p>ажилтанд мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 1 жилийн сургалтын төлбөрийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгосон.</p> <p>2021 онд ажилтанд ажлын бус цагаар, үндсэн ажлаас чөлөөлөгдөлгүйгээр суралцах тохиолдолд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сургалтын төлбөрийг төлөхөд зориулж тэтгэмж хүссэн 3 ажилтанд ИНЕГ-ын даргын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажиллах тухай” А/38 дугаар тушаалын дагуу тэтгэмж олгох боломжгүйг мэдэгдсэн.</p> <p>Мөн МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” ИНЕГ-ын даргын 2021 оны А/38 дугаар тушаалаар төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 3 дугаар улирлын байдлаар тэтгэмж олгогдоогүй байна.</p>
Зорилт 7. Ажилтны гэр бүлийн хөгжлийг дэмжих		
7.	7.1. Шинээр гэр бүл болж байгаа болон залуу гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2019 онд шинээр гэр бүл болсон 9 ажилтанд, 2020 онд 7 ажилтанд, 2021 онд 1 ажилтанд тус бүр 250'000 төгрөгийн дэмжлэг олгосон.
	7.2. Ажилтны цэцэрлэгийн насны хүүхдүүдийн судалгаа, тоон мэдээг нэгтгэн гаргаж, байгууллагын дэргэдэх цэцэрлэг байгуулах	<p>ИНҮТ, түүний харьяа салбар, нэгжийн ажилтнуудын 0-5 насны 688 хүүхдийн судалгааг гаргасан.</p> <p>ИНЕГ нь Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах” зорилтыг хэрэгжүүлэхээр “Байгууллагын цэцэрлэг” санаачлагад нэгдэн 2020 онд өөрийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн цэцэрлэг байгуулж, ХУД-ийн ЗДТГ-аас Нийслэлийн 250 дугаар цэцэрлэгийн “Буянт-Ухаа” салбар болгон ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу 2021 оны 9 дүгээр сараас үйл ажиллагааг нь эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны шийдвэрээр 2020-2021 оны хичээлийн жилд 4, 5 настай хүүхдүүдийг цэцэрлэгт танхимаар хамруулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу ИНЕГ-ын болон харьяа салбар, нэгжийн, агаарын тээвэрлэгчдийн ажилтнуудын 90 хүүхэд бүртгүүлэн цэцэрлэгт хамрагдаж байна.</p>
	7.3. Ажилтны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг гаргаж, хүүхдээ асарч, сувилахад нь зориулж, тэтгэмж тусламж олгох	<p>ИНҮТ, түүний харьяа алба, нэгжийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 25 ажилтан байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, сувилахад нь зориулж 2019 онд 3 ажилтанд, 2020 онд 14 ажилтанд, 2021 онд 2 ажилтанд тус бүр 500'000 төгрөгийн тэтгэмж олгосон.</p>

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР